БАТЛАВ:
ХЭНТИЙ АЙМГИЙН ЕРӨНХИЙ
АРХИТЕКТОР Д.ГАНТӨГС

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМАНД БАЙГУУЛАГДАХ**
**"ЭЗЭНТ ГҮРЭН" МИНИ ПАРКИЙН АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВАР**

2020-01-20 Дугаар 2020/005 Чингис хот

| № | Асуулт | Ерөнхий шаардлага Тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барилга байгууламжийн нэр, хүчин чадал /зориулалт/ | **Нэр:** "Эзэнт гүрэн" мини парк<br>**Хүчин чадал:** 5 га<br>- хөшөө / Хаадын хөшөө /<br>- бусад барилга байгууламжын хүчин чадлыг тооцоогоор гаргах<br>**Зориулалт:** Худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээний барилга /Аялал, жуулчлалын/ |
| 2 | Барилга байгууламжийн байршилт | Хэнтий аймаг, Хэрлэн сумын 1-р баг Гүндгаравлин хийдийн зүүн урд Хэрлэн голын эрэг дагуу |
| 3 | Газар олголтын захирамж байршил хэмжээ | Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын 2020 оны .. -р сарын ...-ний өдрийн ..... дугаар захирамжаар олгосон Хэрлэн сумын 1-р баг Гүндгаравлин хийдийн зүүн урд байрлах 5 га газар |
| 4 | Барилгын хэмжээ /тэнхлэгээрээ/ | Тооцоогоор. Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНбД-30-01-04, Олон нийт иргэний барилга БНбД 31-03-03 дагуу тооцож гаргах |
| 5 | Барилгын бүтээцийн төрөл, давхрын тоо | Барилга байгууламжийг 2 давхар хүртэл байгаль орчинд ээлтэй орон нутгийн материал, сэргээгдэх эрчим хүч, саарал ус, цахилгаан халаагч ашигласан эко шийдэлтэй, өнгө үзэмж сайтай шинэ шийдлээр төлөвлөх |
| 6 | Эдэлбэр газрын барилгажих талбай : үүнд<br>-барилгажих талбай 60 хувиас хэтрэхгүй<br>-ногоон байгууламж гадна тохижилт 30 хувиас дээш<br>-авто зогсоол<br>-гараж туслах барилга | Эдэлбэр газар 5 га<br>Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм БНбД-30-01-04 дагуу төлөвлөх |
| 7 | Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтонд тавигдах шаардлага | - Төлөвлөлтийн талбайд Хаадын хөшөөт цогцолбор, амралт зугаалгын бүс /ногоон байгууламж, усан оргилуур, хиймэл нуур/, амралтын бүс, худалдаа үйлчилгээний бүс, аж ахуйн бүс, инженерийн дэд бүтцийн бүс, нөөц талбай, спорт талбай, тоглоомын талбай, хог хаягдлын төвлөрсөн цэг, дугуйн зам, авто зогсоол төлөвлөх ба жилийн 4 улиралд дотоодын болон гадаадын |

| | | |
|---|---|---|
| | | жуулчдыг авах боломжтой байхаар төлөвлөх |
| 8 | Архитектур төлөвлөлтийн шаардлага | - Мянганы суут хүн их эзэн Чингис хааны түүхэн аялал жуулчлалын үндэсний парк цогцолборын нэг хэсэг болгож түүхэн сэдэвчилсэн зохиомжтой архитектур төлөвлөлтийн шийдэл гаргах<br>- Түүхэн дурсгалын өв соёлыг хадгалсан их хаадын хөшөө дурсгал төлөвлөх<br>- Мини паркийн авто зам, явган хүний замыг орон нутгийн материал болох байгалийн чулуу, мод зэргийг ашиглан зохиомжилж төлөвлөх<br>- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг заавал хийлгэх |
| 9 | Хот төлөвлөлтийн онцгой шаардлага | - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНбД-30-01-04, Олон нийт иргэний барилга БНбД 31-03-03, Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНбД-21-02-02-ыг баримтлан төлөвлөх<br>- Инженер геологийн судалгаа хийж, хэсэг бүрт хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоон барилга байгууламжийн бүтээцийг тооцоогоор оновчтой сонгох. Хөрсний шинж чанараас шалтгаалан барилгын суурийг оновчтой сонгох<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх |
| 10 | Талбайн өндөржилтөнд тавигдах шаардлага | Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг орчны барилгуудтай уялдуулж талбайн хэмжээнд иж бүрэн цогц байдлаар шийдэх |
| 11 | Инженерийн шугам сүлжээнд тавих шаардлага | Байгаль орчинд ээлтэй сэргээгдэх эрчим хүч, саарал ус, цахилгаан халаагч эко шийдэл бүхий инженерийн байгууламж төлөвлөх |
| 12 | Инженерийн бэлтгэл арга хэмжээ / үерийн хамгаалалт далан суваг шуудуу зайлуулах арга хэмжээ/ | Гадаргын ус зайлуулалтыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх |
| 13 | Захиалагчийн хаяг утас | Хэнтий аймгийн Хэрлэн сумын ЗДТГазар |

Анхааруулга:

Барилга байгууламж төлөвлөхөд байгаль орчин болон өмнө нь хийгдсэн зам талбайг хөндөх бол нөхөн сэргээх!

**Боловсруулсан:**

Хэнтий аймгийн ГХБХБГазрын Хот байгуулалтын кадастр,
зураг төсөл магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн ......./Ш.Ариунболор/